

ХУВИЙН АШИГ СОНИРХОЛ, ХӨРӨНГӨ ОРЛОГЫН МЭДҮҮЛГИЙН ТОГТОЛЦООНЫ ҮР НӨЛӨӨГ ХЭРХЭН САЙЖРУУЛАХ ВЭ?

Болдын Цолмон /ННФ-ын Засаглалын хөтөлбөрийн менежер/

ХУВИЙН АШИГ СОНИРХОЛ, ХӨРӨНГӨ ОРЛОГЫН МЭДҮҮЛГИЙН ТОГТОЛЦООНЫ ҮНДСЭН ҮҮРЭГ

Нийтийн албан тушаалтнууд хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогоо мэдүүлэх нь авлига болон ашиг сонирхлын зөрчилтэй тэмцэх, төрийн албаны ил тод байдлыг хангахад чухал ач холбогдолтой юм. Энэ утгаараа хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийн тогтолцоо нь ашиг сонирхлын зөрчил, авлигын хэргийг илрүүлэх, зөрчил гаргасан албан тушаалтанд хариуцлага тооцох хэрэгсэл болдог ажээ. Гэхдээ уг тогтолцооны үндсэн үүрэг нь ашиг сонирхлын зөрчил, авлигаас урьдчилан сэргийлэх явдал билээ. Монгол Улсад одоогоор

үйлчилж байгаа тогтолцоо энэхүү үүргийг төдийлөн сайн гүйцэтгэж чадахгүй байна. Учир нь, нийтийн албан тушаалтнууд мэдүүлгээ үнэн зөв бөглөсөн эсэхийг шалгах хяналт учир дутагдалтай байгаа юм.

ХУВИЙН АШИГ СОНИРХОЛ, ХӨРӨНГӨ ОРЛОГЫН МЭДҮҮЛГИЙГ ШАЛГАХ ӨНӨӨГИЙН ТОГТОЛЦОО

Манай оронд нийтийн албан тушаалтнууд 2007 оноос хөрөнгө орлогоо, 2012 оноос хувийн ашиг сонирхлоо мэдүүлж эхэлсэн бөгөөд сүүлийн 3 жилийн байдлаар Авлигын эсрэг хуулийн дагуу мэдүүлэг гаргах ёстой албан тушаалтнуудын 99.9 хувь нь мэдүүлгээ гаргаж байна. Мэдүүлгийн бүрдүүлэлт ийнхүү өндөр үзүүлэлттэй

байгаа ч түүнийг шалгах арга нь авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нөхцлийг бүрэн хэмжээнд бий болгож чадахгүй байна.

Авлигатай тэмцэх газрын Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсээс мэдүүлгийн агуулгыг дараах тохиолдолд шалгадаг байна¹:

- иргэдээс өргөдөл, гомдол, мэдээлэл ирсэн тохиолдолд
- мэдүүлгийг хугацаанд нь гаргаж өгөөгүй, эсхүл хөрөнгө, орлогын эх үүсвэрийг заагаагүй буюу түүнийг хэрхэн олсон талаар тайлбар гаргаагүй тохиолдолд
- төлөвлөгөөт хяналт шалгалтын хүрээнд.



Болдын Цолмон

Б.Цолмон Нээлттэй Нийгэм Форумаас засаглалын хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлж буй ажлууд, үүний дотор төрийн ил тод, хариуцлагатай байдлыг хангах механизмуудыг боловсронгуй болгоход чиглэсэн судалгаа, шинжилгээг хариуцан ажилладаг. Тэрээр Засгийн Газрын Хэрэг эрхлэх газарт шинжээчээр, “Хүний аюлгүй байдлын судалгааны төв” ТББ-д төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулахад чиглэсэн “Нэг цонхны үйлчилгээ” төслийн ажилтнаар тус тус ажиллаж байсан бөгөөд Япон Улсын Софиягийн Их Сургуульд Олон улсын харилцааны чиглэлээр магистрын зэрэг хамгаалжээ.

ННФ нь бодлого боловсруулах үйл явцад иргэд, иргэний нийгмийн идэвхтэй оролцоог дэмжих, чанартай судалгаа мэдээллээр бодлого боловсруулагчид, олон нийтийг хангах зорилготой байгууллага юм.

Дээрх гурван төрлийн шалгалтаас төлөвлөгөөт хяналт шалгалт нь мэдүүлгийн агуулгыг тогтмол хугацаанд, системтэйгээр шалгах арга юм. Шалгалтад хамруулах байгууллагуудыг авлигалд өртөх магадлал өндөр гэж Авлигатай тэмцэх газрын судалгаагаар² тогтоосон байгууллагууд дундаас сонгож, жил бүр хийдэг ажээ. Энэ хүрээнд Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн Мэдүүлгийн бүрдүүлэлт, дүн шинжилгээний алба нь сүүлийн хоёр жилийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг харьцуулж, илт зөрчилтэй эсхүл зөрчилтэй байх магадлалтай гэж үзсэн мэдүүлгүүдийг нарийвчлан шалгуулахаар тус хэлтсийн Хяналт шалгалтын албанд шилжүүлдэг байна. Хяналт шалгалтын алба нь хөрөнгө орлогын мэдүүлэгт бичсэн мэдээллийг төрийн холбогдох бүртгэл, хяналтын байгууллагаас авсан мэдээлэл, лавлагаатай харьцуулж, хянан шалгадаг аж. Мэдүүлээгүй, эсвэл худлаа мэдүүлсэн хөрөнгө, орлогын хэмжээнээс хамаарч, зөрчил гаргасан албан тушаалтанд сахилгын шийтгэл хүлээлгэдэг байна. Харин орлогынхоо эх үүсвэрийг тайлбарлаж чадахгүй тохиолдолд тухайн албан тушаалтныг хууль бусаар хөрөнгөжсөн гэж үзээд эрүүгийн хариуцлага хүлээлгэх зохицуулалтыг 2012 онд бий болгожээ. Үүнээс гадна, төлөвлөгөөт хяналт шалгалтын явцад албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг хянан шалгаж, зөрчил илэрсэн тохиолдолд зохих хариуцлага тооцуулахаар тухайн байгууллагын удирдлагад албан бичиг хүргүүлдэг юм.

Хэдийгээр төлөвлөгөөт хяналт шалгалтыг жил бүр хийдэг ч, тухайн онд мэдүүлгээ шалгуулсан албан тушаалтан дараагийн жилд дахин шалгуулах магадлал бараг үгүй юм байна. Үүнээс гадна шалгалтад хамруулж буй мэдүүлгийн тоо цөөхөн байдаг ажээ. Мэдүүлгийн агуулгыг шалгах дээр дурдсан гурван үндэслэлээр 2012 онд 316³, 2013 онд 557⁴ мэдүүлэг шалгасан бөгөөд энэ нь тухайн жил бүртгэж авсан нийт 47,000 орчим мэдүүлгийн 0.7-1 хувьтай тэнцэхүйц юм. Эндээс харахад, төлөвлөгөөт хяналт шалгалтад хамруулж буй мэдүүлгийн хувь үүнээс ч бага байгаа юм. Энэ нь нийтийн албан тушаалтны хувьд шалгалтад хамрагдах, улмаар зөрчил илэрсэн тохиолдолд хариуцлага хүлээх магадлал бага байгааг харуулж буй. Ийм байдал нийтийн албан тушаалтнууд авлига авах, хувийн ашиг сонирхлоо нийтийнхээс дээгүүр тавих, мөн энэ талаар үнэн зөв мэдүүлэхгүй байхад нөлөөлж байна.

ХУВИЙН АШИГ СОНИРХОЛ, ХӨРӨНГӨ ОРЛОГЫН МЭДҮҮЛГИЙН ТОГТОЛЦООНЫ ҮР НӨЛӨӨГ САЙЖРУУЛАХ АРГА

Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийн тогтолцооны голлох үүрэг болох авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх үүргийг бэхжүүлэхэд юу хийх шаардлагатай вэ?

Олон улсын сайн туршлагаас харахад *random audit* буюу мэдүүлгийг санамсаргүй сонголтоор сонгон шалгах аргыг нэвтрүүлэх хэрэгтэй юм⁵. Мэдүүлгийг шалгах энэхүү арга нь дараах алхмуудаас бүрддэг байна:

- 1) тухайн жил шалгалтад хамруулах мэдүүлгийн тоог олон нийтэд урьдчилж зарлах
- 2) хянан шалгах мэдүүлгүүдийг нийт бүртгэж авсан мэдүүлгүүдээс сугалааны аргаар ил тод сонгох
- 3) шалгалтын дэлгэрэнгүй дүнг цаг алдалгүй олон нийтэд хүргэх.

Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг санамсаргүй сонголтоор сонгон шалгах аргыг нэвтрүүлэхийн давуу тал нь:

- Мэдүүлэг гаргаж буй бүх албан тушаалтнуудын шалгалтад хамрагдах магадлал нэмэгдэх бөгөөд энэ магадлал нь мэдүүлэг гаргагч бүрийн хувьд адилхан байх болно;
- Заавал олон тооны мэдүүлэг шалгах шаардлагагүй, харин тухайн онд бүртгэж авсан нийт мэдүүлгийн урьдчилж зарласан тодорхой хувийг л шалгахад хангалттай.

Мэдүүлгийг санамсаргүй сонголтоор сонгон шалгах энэхүү арга бол ашиг сонирхол, хөрөнгө орлогоо худлаа мэдүүлэхээс үүсэх эрсдлийг нэмэгдүүлж, улмаар үүнээс урьдчилан сэргийлэх хөшүүрэг болдог ажээ. Мөн бүртгэж авсан нийт мэдүүлгийн зөвхөн тодорхой хувийг шалгах тул хүн хүч, хөрөнгө мөнгө хязгаарлагдмал нөхцөлд шалгалт хийх үүрэгтэй байгууллагад хүнд дарамт болохгүй. Иймээс мэдүүлгийг шалгах энэ аргыг нэвтрүүлэх нь хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийн тогтолцооны үр нөлөөг сайжруулах, улмаар нийтийн албан дахь хувийн ашиг сонирхол, авлигын хэргийн тоог бууруулахад ихээхэн ач холбогдолтой юм.

МЭДҮҮЛГИЙГ ХЯНАН ШАЛГАХ БУСАД ОРНЫ САЙН ТУРШЛАГА

- Словени Улсын Авлигаас урьдчилан сэргийлэх хороо жилд ойролцоогоор 14,000 хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлэг бүртгэн авч, санамсаргүй сонголтын аргаар шалгадаг байна. Шалгалтад хамруулах мэдүүлгийн тоо хянан шалгах ажил гүйцэтгэх бололцоотой ажилтны тооноос хамаарч, жилээс жилд хэлбэлздэг. Тухайлбал, 2009 онд Авлигаас урьдчилан сэргийлэх хороо бүртгэж авсан нийт мэдүүлгийнхээ 33 хувийг шалгасан бөгөөд нэг ажилтан 413 мэдүүлэг хянажээ.
- Аргентин Улсын Хөрөнгө орлогын хэлтэс нь гүйцэтгэх засаглалд алба хашдаг 36,000 албан тушаалтны хөрөнгө орлогын мэдүүлгийг жил бүр бүртгэж авдаг. Эдгээрээс хамгийн өндөр албан тушаалтныг хамруулан мэдүүлгийн эхний 5 хувийг сонгон авч шалгадаг байна. Энэ хүрээнд 2009 онд 1,600 албан тушаалтны хөрөнгө орлогын мэдүүлгийг шалгажээ. Мэдүүлгийн үлдсэн 95 хувийг шалгахдаа тухайн албан тушаалтны авлигалд өртөх эрсдлийг нь харгалзаж хянадаг юм. Хөрөнгө орлогын хэлтэс нь жилд 2,500 орчим мэдүүлэг шалгах бололцоотой ажээ.
- Руанда Улсын Омбудсманы албанд жилд 5,000 орчим албан тушаалтан хөрөнгө орлогын мэдүүлгээ гаргаж өгдөг байна. Шалгалтад хамруулах мэдүүлгийн түүврийг албан тушаал харгалзан сонгодог бөгөөд сонгон авсан мэдүүлэг дотроос санамсаргүй сонголтын арга хэрэглэн 6 хувийг нь шалгадаг ажээ. Ингэхдээ албан тушаалтны мэдүүлсэн хөрөнгө орлого нь банкинд болон үл хөдлөх хөрөнгийн, газрын, татварын зэрэг мэдээллийн сангуудад байгаа мэдээлэлтэй нийцэж байгаа эсэхийг шалгахаас гадна тухайн албан тушаалтны гэрт нь очих болон амьдралынх хэв маягийг нь шалгах бусад үйл ажиллагаа явуулдаг байна.

1 Авлигын эсрэг хуулийн 13-р зүйл: “Хөрөнгө, орлогын мэдүүлгийг хянан шалгах, хариуцлага хүлээлгэх үндэслэл”

2 Монголын Авлигын индексийн судалгаа, төрийн байгууллагын шударга байдлын түвшиний судалгаа, улс төр, хууль хяналтын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн судалгаа

3 Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн 2012 оны үйл ажиллагааны жилийн тайлан, http://www.iaac.mn/pdf/tailan/hyanalt_shalgalt_tailan2012.pdf болон Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн үйл ажиллагаатай холбоотой статистик мэдээлэл, <http://iaac.mn/content/215#.U6JeBRvlpMs>

4 Авлигатай тэмцэх газрын 2013 оны үйл ажиллагааны товч тайлан, <http://www.iaac.mn/content/388#.U6JgWxvlpMt>

5 Opening government, a guide to best practice in transparency, accountability and civic engagement across public sector, <http://www.transparency-initiative.org/wp-content/uploads/2011/09/Opening-Government.pdf>